



МОНГОЛ УЛСЫН
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙДЫН
ТУШААЛ

2025 оны 02 сарын 20 өдөр

Дугаар А/49

Улаанбаатар хот

Дүрэм шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалт, мөн хуулийн 15 дугаар зүйлийн 15.3.5 дахь заалт, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4.6, 5.4.10 дахь заалт, 13 дугаар зүйлийн 13.1, 13.4 дэх хэсэг, Батлан хамгаалах яамны Шинжлэх ухаан, технологи, инновацын зөвлөлийн 2025 оны анхдугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Батлан хамгаалах яамны Шинжлэх ухаан, технологи, инновацын зөвлөлийн дүрмийг хавсралтаар баталсугай.

2.Энэ дүрмийг батлагдсан өдрөөс эхлэн үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг яамны Шинжлэх ухаан, технологи, инновацын зөвлөл (бригадын генерал Д.Ганхуяг), холбогдох байгууллагуудад үүрэг болгосугай.

3.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Батлан хамгаалахын сайдын 2017 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн “Дүрэм батлах тухай” А/88 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (хурандаа Б.Эрхэмбаяр)-т даалгасугай.

САЙД



С.БЯМБАЦОГТ

1325100098

Батлан хамгаалахын сайдын 2025 оны
02 дугаар сарын 02-ны өдрийн
449 дугаар тушаалын хавсралт

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИ, ИННОВАЦЫН ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү дүрмээр Батлан хамгаалах яамны Шинжлэх ухаан, технологи, инновацын зөвлөл (цаашид "Зөвлөл" гэх)-ийн баримтлах бодлого, үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Зөвлөл нь шинжлэх ухаан, технологи, инновацын талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, харьяа байгууллага, тэдгээрийг түшиглэсэн туршилт, судалгааны төвүүдийн оролцоог хангах, салбарын шинжлэх ухаан, технологи, инновацын бодлого, чиглэл, зорилтыг тодорхойлох, түүний хэрэгжилтийн явц, үр дүнг хэлэлцэж санал, дүгнэлт, зөвлөмж гаргах, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл мөн.

1.3. Зөвлөл нь Батлан хамгаалахын сайдын зөвлөлд жил бүрийн 4 дүгээр улиралд багтаан ажлаа тайлагнана.

1.4. Зөвлөл нь албан хэрэгтээ тогтоосон стандартад нийцсэн албан бичгийн хэвлэмэл хуудас, Батлан хамгаалахын яамны тамга, тэмдэг хэрэглэнэ.

1.5. Зөвлөлийн үйл ажиллагааны зардал болон батлан хамгаалах салбарт хэрэгжүүлэх шинжлэх ухаан, технологи, инновацын судалгааны ажилд зарцуулах санхүүжилтийг Батлан хамгаалахын сайдын багц, Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн төсөвт тусган санхүүжүүлнэ.

Хоёр. Зөвлөлийн удирдлага, зохион байгуулалт

2.1. Зөвлөл нь дарга, орлогч дарга, эрдэмтэн нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэнэ.

2.2. Зөвлөлийн дарга нь Төрийн нарийн бичгийн дарга, орлогч дарга нь Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга байна.

2.3. Зөвлөл нь орон тооны эрдэмтэн нарийн бичгийн даргатай байна. Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын шинжлэх ухаан, технологи, инновацын бодлогын шинжээч нь Эрдэмтэн нарийн бичгийн даргын үүргийг гүйцэтгэнэ.

2.4. Зөвлөлийн бүрэлдэхүүн нь Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, харьяа газар, эрдэм шинжилгээ, сургалтын байгууллага, Хуурай замын цэргийн болон Агаарын цэргийн командлалын удирдах албан тушаалтан, эрдэмтэд, залуу судлаачдын төлөөллөөс бүрдсэн 15 гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн 2/3 хүртэл хувь нь боловсролын доктор, түүнээс дээш эрдмийн зэрэгтэй байна.

2.5. Зөвлөл нь дэргэдээ дараах салбар болон мэргэжлийн зөвлөлтэй байна:

2.5.1. цэргийн шинжлэх ухаан, аюулгүй байдал, батлан хамгаалах судлалын салбар зөвлөл;

2.5.2. техник, технологи, инновацын салбар зөвлөл;

2.5.3. техник, технологийн мэргэжлийн зөвлөл гэсэн бүтэцтэй байх бөгөөд салбар зөвлөл нь 7 хүний бүрэлдэхүүнтэй байна.

Мэргэжлийн зөвлөлийн ажиллах журмыг Батлан хамгаалахын сайдын тушаалаар баталгаажуулна.

2.6. Зэвсэгт хүчний Жанжин штаб, Үндэсний батлан хамгаалахын их сургууль, Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн, Цэргийн төв эмнэлэг нь Шинжлэх ухаан, технологи, инновацын салбар зөвлөл (Эрдмийн зөвлөл)-тэй байх ба зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрэм, үйл ажиллагааны төлөвлөгөөг тухайн байгууллагын захирал, дарга нар тус тус баталж, хэрэгжүүлнэ.

2.7. ЗХХЖШ-ын Шинжлэх ухаан, технологи, инновацын салбар зөвлөл нь орон тооны нарийн бичгийн дарга, нэгдсэн зохицуулагчтай байна.

2.8. Зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагааны дүрэм, холбогдох журмыг батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

Гурав. Зөвлөлийн үйл ажиллагаа

3.1. Зөвлөл нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, Технологи дамжуулах тухай хууль, Инновацын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, батлан хамгаалах салбарт шинжлэх ухаан, технологи, инновацыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого, стратегийн зорилт, тэргүүлэх чиглэл, энэ дүрмийг удирдлага болгоно.

3.2. Зөвлөл нь үйл ажиллагааныхаа төлөвлөлтийг жил бүр ээлжит хуралдаанаар хэлэлцэж, хэрэгжүүлнэ.

3.3. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь зөвлөлийн хуралдаан байх бөгөөд зөвлөлийн гишүүдийн ирц 60 ба түүнээс дээш байх тохиолдолд хуралдааныг хүчинтэйд тооцно. Зөвлөлийн хуралдаанд цахимаар оролцох, эсвэл урьдчилж санал өгсөн гишүүнийг ирцэд тооцно.

Зөвлөлийн даргын эзгүйд түүнийг зөвлөлийн орлогч дарга орлож, ээлжит хуралдааныг удирдана. Зөвлөлийн өдөр тутмын үйл ажиллагааг эрдэмтэн нарийн бичгийн дарга зохион байгуулна.

3.4. Зөвлөлийн хуралдааны тов, хэлэлцэх асуудлыг Зөвлөлийн дарга шийдвэрлэж, хуралдааны дэгийг батална.

3.5. Зөвлөлийн хуралдааныг улиралд 1 удаа хуралдуулна. Шаардлагатай үед зөвлөлийн даргын шийдвэрээр хуралдааныг энэ дүрмийн 3.3-т заасан ирцтэйгээр зохион байгуулж болно.

Зөвлөлийг шаардлагатай тохиолдолд мэргэжлийн эрдэмтэн, судлаач, албан тушаалтан оролцуулан өргөтгөн хуралдуулж болно.

3.6. Зөвлөлийн хуралдааны шийдвэрийг хуралдаанд оролцсон гишүүдийн 70 ба түүнээс дээш хувийн саналаар дэмжсэн тохиолдолд хүчинтэйд тооцно.

Зөвлөлийн гишүүд хуралдаанаар хэлэлцэгдэж байгаа асуудалд өгөх санал аа хуралдаан эхлэхээс 1 хоногийн өмнө, эсхүл хуралдааны явцад өгнө. Хуралдаан дууссанаас хойш тухайн асуудлаар нэмэлт санал өгөхгүй.

3.7. Эрдэмтэн нарийн бичгийн дарга нь зөвлөлийн хуралдааны бэлтгэл ажлыг хангаж, зохион байгуулна.

3.8. Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлын үндэслэл, хэрэгцээ, шаардлага бүхий танилцуулга болон холбогдох бусад материалыг хуралдаан эхлэхээс ажлын хоёроос доошгүй хоногийн өмнө гишүүдэд тараана.

3.9. Зэвсэгт хүчний Жанжин штаб, Үндэсний батлан хамгаалахын их сургууль, Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн, Цэргийн төв эмнэлэг нь яамны Шинжлэх ухаан, технологи зөвлөлтэй хамтран ажиллах ба тэдгээр нь батлан хамгаалах судлал, цэргийн шинжлэх ухаан, технологи, инновацыг хөгжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажлын үр дүнг зөвлөлд жил бүрийн 4 дүгээр улиралд багтаан тайлагнана.

3.10. Зөвлөл нь хэлэлцсэн асуудлынхаа хүрээнд шийдвэр гаргана. Зөвлөлийн шийдвэр нь Батлан хамгаалахын сайдын тушаал, Зөвлөлийн даргын тогтоолоор баталгаажиг хэрэгжинэ.

3.11. Зөвлөлийн гишүүн хүндэтгэн үзэх шалтгаантайгаас бусад тохиолдолд хуралдаанд заавал оролцоно.

Тайлбар: хүндэтгэн үзэх шалтгаанд өвчтэй, ар гэрийн гачигдалтай, эсхүл гадаад улсад болон орон нутагт албан томилолтоор ажилласныг тооцно.

3.12. Зөвлөлийн бүрэлдэхүүний идэвх санаачилга, хуралдаан болон бусад үйл ажиллагаанд оролцсоны үр дүнг харгалзан зөвлөлийн дарга, орлогч дарга, эрдэмтэн нарийн бичгийн дарга, гишүүдэд тэдгээрийн 1 хүртэлх сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг жилд 1 удаа Батлан хамгаалахын сайдын тушаалаар олгож болно.

Тайлбар: Батлан хамгаалахын сайдын 2024 оны "Батлан хамгаалах яамны Шинжлэх ухаан, технологи, инновацын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай" А/384 дүгээр тушаалаар батлагдсан бүрэлдэхүүн, мөн тушаалын хавсралтаар батлагдсан салбар болон мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүнд олгоно.

3.13. Зөвлөлийн гишүүн хүндэтгэх шалтгаангүйгээр хуралдаанд хоцорсон, эсхүл оролцоогүй бол түүнд холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.

Тайлбар: Зөвлөлийн гишүүн нь энэ дүрмийн 3.11-т заасан хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хуралдаанд удаа дараа оролцоогүй, 2-оос дээш удаа хоцорсон болон хуралдаанд идэвх, санаачилгагүй оролцсон тохиолдолд энэ дүрмийн 3.12-т заасан мөнгөн урамшууллыг олгохгүй байх үндэслэл болно.

Дөрөв. Зөвлөлийн эрх, үүрэг

4.1. Зөвлөл нь дараах эрх эдэлнэ:

4.1.1.эрхлэх асуудлын хүрээнд зөвлөлийн хуралдааныг зохион байгуулах, хэлэлцэн шийдвэрлэх;

4.1.2.урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, салбарын шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэл, жилийн нарийвчилсан төлөвлөгөөнд тусгагдсан шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх зорилт, үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, үр дүнг үнэлэх;

4.1.3.салбарын хэмжээнд хэрэгжүүлэх шинжлэх ухаан, технологи, инновацын захиалгат судалгааны ажлын даалгавар өгч, гүйцэтгүүлэх, захиалсан судалгааны ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

4.1.4.шинжлэх ухаан, технологи, инновацын чиглэлээр дотоодын болон олон улсын байгууллагаас зохион байгуулж буй төсөл, хөтөлбөр, эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөн, семинарт эрдэмтэн, судлаачдыг оролцуулах;

4.1.5.салбарын эрдэм шинжилгээний байгууллагын удирдлага, бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох санал боловсруулах;

4.1.6. яамны харьяа эрдэм шинжилгээ, сургалтын байгууллага, ЗХЖШ, харьяа цэргийн нэгтгэл, анги, байгууллагууд, тэдгээрийг түшиглэсэн туршилт, судалгааны төвүүдийн шинжлэх ухаан, технологи, инновацын судалгаа боловсруулалтын ажил, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагаанд мэргэжлийн дэмжлэг үзүүлэх;

4.1.7. үндэсний батлан хамгаалахын их сургуулийн магистр, докторын сургалт, хамгаалуулах зөвлөлийн үйл ажиллагааг бодлогын удирдамжаар хангах;

4.1.8. орчин үеийн дэвшилтэд технологи, хиймэл оюун ухаанд суурилсан зэвсэглэл, цэргийн техник хэрэгслийн судалгаа боловсруулалтын ажлыг санаачлан хэрэгжүүлэх;

4.1.9. цэргийн болон цэрэг-техникийн хамтын ажиллагаатай орнуудтай дэвшилтэт технологи нутагшуулах, Зэвсэгт хүчний зэвсэглэл, техник, хэрэгслийг шинэчлэх асуудлаар гэрээ, хэлэлцэл байгуулахад санал, зөвлөмж өгөх;

4.1.10. батлан хамгаалах бодлого, үндсэн үйл ажиллагааны чиглэлээр судалгааны даалгавар боловсруулан гүйцэтгүүлэх, түүнд эрдэмтэн, судлаач, мэргэжилтнүүдийг татан оролцуулах;

4.1.11. Батлан хамгаалахын сайдын нэрэмжит шилдэг бүтээлээр шалгарсан бүтээлүүдийг Зэвсэгт хүчний зэвсэглэлд нэвтрүүлэх, олноор үйлдвэрлэх, шинэчлэн сайжруулах, төсөл, хөтөлбөр болгон хэрэгжүүлэх, сургалт судалгааны эргэлтэд оруулах асуудлыг дэвшүүлэх;

4.1.12. шинжлэх ухаан, технологи, инновацын асуудлаар БХЯ, ЗХЖШ-ын харьяа байгууллагаас холбогдох мэдээллийг гаргуулан авах;

4.1.13. салбар зөвлөл, яамны харьяа эрдэм шинжилгээ, сургалтын байгууллага, ЗХЖШ, харьяа цэргийн нэгтгэл, анги, байгууллагууд, тэдгээрийг түшиглэсэн туршилт, судалгааны төвүүдийг үүрэг чиглэлээр хангах;

4.1.14. цэргийн шинжлэх ухаан, аюулгүй байдал, батлан хамгаалах судлалыг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан, үр бүтээлтэй ажилласан эрдэмтэн, залуу судлаачдыг урамшуулах асуудлыг хэлэлцэн, холбогдох байгууллагад тодорхойлох.

4.2. Зөвлөл дараах үүрэг хүлээнэ:

4.2.1. батлан хамгаалах хэрэгцээ, шаардлагад нийцсэн шинжлэх ухаан, технологи, инновацын талаар баримтлах бодлого, стратегийн зорилт, тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

4.2.2. батлан хамгаалах салбарт шинжлэх ухаан, технологи, инновацыг хөгжүүлэх эрх зүйн орчин бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлж, салбарын шинжлэх ухаан, технологи, инновацын чадавхыг хөгжүүлэх төсөв, зардлыг шийдвэрлэх;

4.2.3. шинжлэх ухаан, технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, Шинжлэх ухааны академи, Үндэсний шинжлэх ухаан, технологийн сан, их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран ажиллах;

4.2.4. аюулгүй байдал, батлан хамгаалах асуудлаар шинжлэх ухаан, технологи, инновацын чадавхыг нэмэгдүүлж, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын онол, аргазүйн түвшин, үр дүнг дээшлүүлэх, шинжлэх ухаан, сургалт, үйлдвэрлэлийн холбоог бэхжүүлэхэд чиглэсэн арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

4.2.5. цэргийн шинжлэх ухаан, аюулгүй байдал, батлан хамгаалах судлалаар эрдэм шинжилгээний ажил эрхлэх, судалгаа хийх, сургалт явуулах оюуны мэдлэг, чадавхтай эрдэмтдийн нөөц бүрдүүлэх чиглэлээр бодлого боловсруулж, хэрэгжүүлэх;

4.2.6. батлан хамгаалахад тулгамдсан асуудал, эрэлт хэрэгцээ, хэтийн бодлогод тулгуурлан гадаад улсад техник, технологи, инновацын чиглэл болон шинжлэх ухааны нэн шаардлагатай бусад чиглэлээр эрдэмтэн бэлтгэх асуудлыг хэлэлцэж, Батлан хамгаалахын сайдын зөвлөлийн хуралдаанаар шийдвэрлүүлэх;

4.2.7. цэргийн шинжлэх ухаан, аюулгүй байдал, батлан хамгаалах судлалаар салбарын өмнө тулгамдсан асуудал, шинжлэх ухаан, технологи, инновацыг хөгжүүлэх, цаашдын чиг хандлагыг тодорхойлох чиглэлээр олон улсын болон улс, салбарын хэмжээний эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлэг зохион байгуулах, үр дүнг бодлого, үйл ажиллагаанд ашиглах, сургалт, судалгааны эргэлтэд оруулахад дэмжлэг үзүүлэх;

4.2.8. салбарын шинжлэх ухаан, технологи, инновацын чиглэлээр сэтгүүл эрхлэн гаргаж, эрдэмтэн, залуу судлаачдын бүтээлийг олон нийтэд таниулан сурталчлах, сургалт, судалгааны эргэлтэд оруулах;

4.2.9. салбарын хэмжээний шинжлэх ухаан, технологийн төсөл, хөтөлбөр боловсруулах, Шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад судалгаа боловсруулалтын ажлыг захиалах, хэрэгжүүлэх, хяналт тавих;

4.2.10. хэрэгжүүлсэн судалгаа, боловсруулалт, туршилтын ажлын тайланг хэлэлцэж, үнэлэлт, шүүмж, дүгнэлт өгөх;

4.2.11. судалгаа хөгжүүлэлт, туршилт зохион бүтээх ажлын үр дүнг үйлдвэрлэл, цэргийн хэрэгт нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

4.2.12. батлан хамгаалах яамны захиалгатай улсын төсвийн санхүүжилтээр гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын үр дүнд бий болсон оюуны өмчийг өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах талаар шийдвэр гаргах;

4.2.13. Батлан хамгаалахын сайдын нэрэмжит шилдэг бүтээлийн шалгаруулалтыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, үр дүнг хэлэлцэн шийдвэрийг Батлан хамгаалахын сайдын тушаалаар батлуулах;

4.2.14. шинжлэх ухаан, технологийн төслийн төсөвт өртөг, зардлыг тодорхойлох, хянах, төслийн санхүүжилтийн хэмжээг тогтоох, түүний зарцуулалтад хяналт тавих;

4.2.15. батлан хамгаалах салбарын шинжлэх ухаан, технологи, инновацын тулгамдсан асуудлаар эрдэм шинжилгээ, сургалтын байгууллагын эрдэмтэд, мэргэжилтнүүдээс бүрдсэн комисс, ажлын хэсэг байгуулж, ажиллуулах;

4.3. Эрдэмтэн нарийн бичгийн дарга дараах үүрэг хүлээнэ:

4.3.1. зөвлөлийн тухайн жилийн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавих;

4.3.2. шинжлэх ухаан, технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, Шинжлэх ухааны академи, Үндэсний шинжлэх ухаан, технологийн сан зэрэг байгууллагуудтай хамтран ажиллах, тэдгээрийн үйл ажиллагааг зохицуулах арга хэмжээ авах;

4.3.3. зөвлөлийн хуралдааны бэлтгэл ажлыг хангаж, зохион байгуулах;

4.3.4. Батлан хамгаалах яамны харьяа, эрдэм шинжилгээ, сургалтын байгууллага, Зэвсэгт хүчний Жанжин штабын харьяа цэргийн нэгтгэл, анги, тэдгээрийг түшиглэсэн туршилт судалгааны төвүүдийн батлан хамгаалах судлал, цэргийн шинжлэх ухаан, технологи, инновацын үйл ажиллагааг бодлогын удирдамжаар хангаж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх;

4.3.5.яамны Шинжлэх ухаан, технологи, инновацын зөвлөлийн салбар болон мэргэжлийн зөвлөлүүдийн үйл ажиллагаанд хяналт тавьж, дэмжлэг үзүүлэх;

4.3.6.Батлан хамгаалахын сайдын нэрэмжит шилдэг бүтээлийн шалгаруулалт, шагнал гардуулах болон олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах;

4.3.7.зөвлөлийн үйл ажиллагааны тухайн жилийн тайланг нэгтгэн боловсруулж, зөвлөлийн хуралдаанд танилцуулах.

Тав. Хэлэлцэх асуудал

5.1. Зөвлөл нь доор дурдсан асуудлыг хэлэлцэж зөвлөмж гаргана:

5.1.1.шинжлэх ухаан, технологи, инновацыг хөгжүүлэх төрийн бодлого, тэргүүлэх чиглэл, мастер төлөвлөгөө, үндэсний хөтөлбөр, Засгийн газрын захиалгаар хэрэгжүүлэх шинжлэх ухаан, технологи, инновацын төслийн санал;

5.1.2.шинжлэх ухаан, технологи, инновацын талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлсэн, үр дүн;

5.1.3.аюулгүй байдал, батлан хамгаалах судлал, цэргийн шинжлэх ухаан, технологи, инновацыг хөгжүүлэх бодлого, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөлт, үр дүн;

5.1.4.Батлан хамгаалах яамнаас баримтлах эрдэмтэн бэлтгэх бодлого, түүний хэрэгжилт, үр дүн;

5.1.5.Батлан хамгаалахын сайдын нэрэмжит шилдэг бүтээлийг шалгаруулсан үр дүн, тэдгээрийг Зэвсэгт хүчний зэвсэглэлд нэвтрүүлэх, олноор үйлдвэрлэх, шинэчлэн сайжруулах, төсөл, хөтөлбөр болгон хэрэгжүүлэх, сургалт судалгааны эргэлтэд оруулах асуудал;

5.1.6.салбарын эрдэм шинжилгээ, сургалтын байгууллагын удирдлага, бүтэц, зохион байгуулалт, эрх зүйг боловсронгуй болгох санал боловсруулах, тэдгээрийн үйл ажиллагааны гүйцэтгэл, хүрсэн үр дүн;

5.1.7.докторын зэрэг хамгаалах, академич цол хүртэх, Шинжлэх ухааны академийн бага чуулганы гишүүн болох асуудалд санал, шүүмж, үнэлгээ, дүгнэлт өгөх;

5.1.8.Зэвсэгт хүчний Жанжин штабын Шинжлэх ухаан, технологи, инновацын салбар зөвлөл болон Үндэсний батлан хамгаалахын их сургууль, Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн, Цэргийн төв эмнэлгийн аюулгүй байдал, батлан хамгаалах судлал, цэргийн шинжлэх ухаан, технологи, инновацын талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, үр дүн;

5.1.9.улс, салбарын захиалгат шинжлэх ухаан, технологийн төсөл, хөтөлбөр, судалгааны ажлын санал;

5.1.10.салбарын шинжлэх ухаан, технологи, инновацын суурь болон хэрэглээний (хавсарга) судалгааны ажлын үр дүнг нэвтрүүлэхэд зарцуулагдах санхүүжилтийн хэмжээг тогтоох асуудал;

5.1.11.шинэ технологи, инновацыг нэвтрүүлэх, хиймэл оюун ухаан, өндөр технологи нутагшуулах, шинжлэх ухаан, технологийн парк, инкубатор зэргийг байгуулах үйл ажиллагааны чиглэл;

5.1.12.сургалт, шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн холбоог бэхжүүлэх ажил, арга хэмжээний санал, дүгнэлт;

5.1.13.судалгааны ажил (улсын болон салбарын захиалгат төслүүд)-ын тайлан, үр дүнгийн үнэлэлт, шүүмж, дүгнэлт;

5.1.14.Зэвсэгт хүчний зэвсэглэл, техникийг сэргээн сайжруулах, шинэчлэх асуудал;

5.1.15.улс, салбарын захиалгаар харьяа эрдэм шинжилгээ, сургалтын байгууллага, Зэвсэгт хүчний Жанжин штабын харьяа цэргийн нэгтгэл, анги байгууллагууд, тэдгээрийг түшиглэсэн туршилт, судалгааны төвүүдийн хэрэгжүүлсэн судалгааны ажлын үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлсэн байдал, эдийн засаг, нийгмийн үр нөлөө.

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ
ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИ, ИННОВАЦЫН ЗӨВЛӨЛ